

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-14

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	6-9
2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	9-13
3.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	13-14

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
3 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 07 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Болормаа, Ч.Номин;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Ж.Баярмаа, Л.Гантөмөр, Ч.Лодойсамбуу, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Ц.Туваан, О.Цогтгэрэл, Ө.Шижир.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор

шийдвэрлэнэ.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн “... уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: 1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан нарын 3 гишүүнээс 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 2 гишүүнээс 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Санхүүгийн хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 6
Бүгд: 18
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 34 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр 12 цаг 41 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 07 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. 2026 оны хаврын чуулганы хугацааны Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/-ны анхны хуралдаан эхэлж байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ТББХ-ны 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд ирсэн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Оюунсайханы Алтангэрэл, Жигжидийн Батжаргал, Амгаланбаатарын Ганбаатар, Цагаанхүүгийн Идэрбат, Ням-Осорын Учрал, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Жадамбын Бат-Эрдэнэ, Баярмагнайн Баярбаатар, Тогмидын Доржханд, Лхагвын Мөнхбаатар, Гончигдоржийн Уянгахишиг, Доржзовдын Энхтуяа, Батын Батбаатар, Сандагийн Бямбацогт, Сархадын Зулпхар, Цэндийн Сандаг-Очир, Бадарчийн Хэрлэн гэсэн 17 гишүүн ирцэд орж, хуралдааны ирц 53,1 хувьтай байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ. 1.Үндсэн Хуулийн Цэц /ҮХЦ/-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлт Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх. 2.ҮХЦ-ийн 2026 оны 1 дүгээр дүгнэлт Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх. 3.Монгол УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орьё. Гишүүдийг дуудаарай.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлье. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.2.1-д цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж, бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах гэж. 84.2.2-т энэ хуулийн 84.2.1-д заасны дагуу Байнгын хороод Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолыг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн

зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах гэж тус тус заасан. Ингээд ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. ҮХЦ-ийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг миний бие танилцуулъя.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаан 25 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ҮХЦ-ийн хуралдааны танхимд болсон бөгөөд хуралдааныг ҮХЦ-ийн дарга Баясгалан даргалж, ҮХЦ-ийн гишүүн Гангабаатар, Мөнхсайхан, Цолмон, Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан. ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Отгонбаяр, Номынбаясгалан нар оролцон, УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр УИХ-ын гишүүн миний бие оролцсон.

Энэ хуралдаанаар дээр нэр дурдсан нэр бүхий Монгол Улсын иргэдээс ҮХЦ-д хандан ирүүлсэн мэдээлэл буюу Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэх хугацааг 3 хоногийн дараагаас эхлэн 10 хоногийн дотор буюу долоо хоног хэлэлцэн шийдвэрлэхээр тодорхой заасан байна. Гэтэл Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт долоо хоногийн дараа хэлэлцэж эхлэн саналыг тавьснаас хойш 10 хоногийн дотор буюу 3 хоногийн дотор шийдвэрлэхээр заасан нь УИХ-ын тус асуудлыг хэлэлцэх хугацааг 4 хоногоор багасгасан байна. Иймд тус хуулийн 101 дүгээр зүйлийн 101 дэх хэсэг, 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгүүд Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн хоёр, 43 дугаар зүйлийн нэг дэх, 44 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн холбогдох заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Монгол УИХ-ын итгэмжлэн төлөөлөгч УИХ-ын гишүүн миний бие ҮХЦ-д хандан холбогдох тайлбар хүргүүлсэн. Уг тайлбартаа ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж буй Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх хэсэгт зохих өөрчлөлт оруулан Үндсэн хуулийн холбогдох хэсэгтэй нийцүүлж өөрчлөхөөр тусгасан гэж тайлбартаа хүргүүлсэн.

ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанаас дараах дүгнэлтийг Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гаргасан байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн нэг дэх хэсэгтэй нийцээгүй. 2. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт нийцээгүй. Энэхүү дүгнэлтийг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж хариу ирүүлэхийг УИХ-д уламжилсугай гэжээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Танилцуулга дууслаа. Танилцуулгатай холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гишүүд асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Энэ юу вэ, Ариунзаяа гишүүн асуух юм уу? Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би зүгээр лавлаж нэг зүйл асуух нь тухайн заалт нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж үзвэл тухайн заалтыг нь бүхэлд нь хүчингүй болгох ёстой байдаг гэж зарим хуульчид бол яриад байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр яг энэ асуудлыг бол та ҮХЦ дээр уг нь бас хэлчихсэн юм байна шүү дээ. Бид нар бол өөрсдөө УИХ дээр УИХ-ын дэгийн тухай хууль, УИХ-ын тухай хуулийг өөрчлөн найруулах ийм ажил хийгдэж байгаа, тухайн заалт бол бид нийцүүлэх ажил хийж байгаа гэж хариулсан юм байна. Тэгэхээр одоо бүхэлд нь тухайн заалтыг хүчингүй болгох үүргийг бас хүлээгээд авчихвал хүлээж байна уу, эсвэл зүгээр өөрчлөн найруулаад явчих тэр гарц гаргалгаа нь нээлттэй байна уу гэдгийг тодруулж хэлж өгөхийг хүсэж байна. Яагаад гэвэл энэ дараа дараагийн өөр бусад хуулиудтай холбоотойгоор ямар арга хэмжээ авах вэ гэдэг дээр нэг тийм жишээ болж өгөх болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: 101.2, 102.1 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн ийм дүгнэлт гарсан. Тэрэнтэй холбоотойгоор одоо УИХ-ын тухай хууль болоод УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиуд нэмэлт, өөрчлөлт хийгдэхээр өргөн баригдахаар боловсруулалтын шатдаа явж байна. Яг энэ хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлтөд энэ Үндсэн хуулийн зөрчилтэй 2 заалтыг Үндсэн хуульд заасантай нийцүүлж энэ хугацааг энэ хуулийн нийцлийг хангаж өөрчилж яваа. Тэгэхээрээ одоо өргөн баригдаад, УИХ-аар хэлэлцэгдээд, батлагдахаараа энэ зөрчил арилна. Цэцийн дүгнэлтийн асуудал ингээд шийдэгдэнэ гэсэн ийм тайлбараа ирүүлсэн.

Мөн Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.3-д хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг УИХ хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэсэн Дэгийн хуулийн 84.3 байна. Тэгээд энэ хүрээнд хуулийн нэмэлт, өөрчлөлт боловсрогдоод, ингээд нийцүүлээд засаад явна. Болсон уу, тодруулах уу? Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Би яагаад энэ асуултыг асуусан бэ гэхлээр яах вэ бид нөгөө өмнө нь одоо Тэмүүжин гишүүний бас ахалж байгаа Эрүүгийн хуулийн үг хэлэх эрх чөлөөтэй холбоотой бас нэг заалтын талаар ажлын хэсэг ажиллаж байгаа. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр бас энэхүү 13.14-ийг хүчингүй болгох, эсхүл өөрчлөн найруулах гэдэг дээр яг одоо хэвлэл мэдээллийн салбар болон тэдгээрт юу гэдэг юм тайлбар тавьж байгаа хуульчид бол тухайн заалтыг бүхэлд нь хүчингүй болгох ёстой, өөрчлөн найруулах ямар нэгэн эрх байх ёсгүй гэдэг ийм маргаан өрнөж байгаа учраас бусад хуулиуд бүгдээрээ адилхан. Ер нь УИХ өөртөө яг энэ өөрчлөн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах энэ эрх нь байгаа юм шүү гэдгийг бусад хуулийн жишээн дээр бас бататгаж, энэ асуултыг асуусан юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо танилцуулгатай холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Хамтдаа явчихсан. Гишүүдээ дуудъя, санал хураалт явуулъя. Сая орж ирсэн ирцэд орсон гишүүд.

Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт явуулъя. Орсон уу? Хэрлэн гишүүн санал хураалтдаа бэлдчих, хуруугаа уншуулчих. Болсон уу? Санал хураалт явууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. 18 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт 2. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэн эхэлж гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн, арав хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

3 дахь санал хураалт. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт. 18 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 61,1 хувиар санал дэмжигдлээ.

4 дэх санал хураалт. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Улсын Их Хурал 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ. Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн миний бие танилцуулна.

12.22 цаг

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлт /Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

2 дахь асуудалдаа оръё. ҮХЦ-ийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж эхэлъе. ҮХЦ-ийн 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. ҮХЦ-ийн дүгнэлтийн талаар товч танилцуулгыг УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин хийнэ. Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага ҮХЦ-д гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож, холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн энэ заалт нь Үндсэн хуультай зөрчилдөж байгаа эсэх талаар хүсэлтийг УИХ ҮХЦ-д гаргасан.

Яагаад ҮХЦ-д энэ заалттай холбоотой асуудал гарсан бэ гэхээр 1 дүгээрт, Монгол Улсын Үндсэн хууль дээр Цэцийн харьяалан эрхлэх маргааны асуудлын дотор ийм утга агуулга бүхий маргаан огт байхгүй. 2 дугаарт, шүүхийн эрх зүйн шүүхийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох шүүхийн шинэчлэлийн үйл явцын хүрээнд Монгол Улсын Дээд шүүхийн бүрэн эрхийн хүрээнд энэ төрлийн маргааныг шийдвэрлэх эрхийг УИХ-аас хуульчилж өгсөн байгаа. Тэгээд хуулийн ийм давхардал үүссэн 1 дүгээрт, 2 дугаарт ҮХЦ-тэй холбоотой яг энэ зүйл, заалттай холбогдуулаад УИХ-ыг захиргааны шүүхэд дуудах тийм процесс бас явсан байсан. Энэнтэй холбоотойгоор УИХ бол өнгөрсөн онд хүсэлт гаргаж, ҮХЦ-д энэ төрлийн маргааныг шийдвэрлэж, ҮХЦ-ийн хэрэг маргаан шийдвэрлэх хууль дээр байгаа 14 дүгээр зүйлийг хүчингүй болгох тухай асуудалтай бол бид ярилцсан.

УИХ бол өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд хуулийг шууд өөрчлөөд хүчингүй болгож болох байсан. Гэхдээ ҮХЦ-ийн хууль тогтоомжид хүндэтгэлтэй хандах байдлаар УИХ бол Цэцээр энэ асуудлыг шийдүүлэх нь зохимжтой юм байна гээд хүсэлт гаргасан. Тэгээд ҮХЦ энэ оны 01 дүгээр тогтоолоороо буюу нэг сард хуралдаад энэ хүсэлттэй холбогдуулаад 2 шийдвэр, 2 үндэслэл бүхий шийдвэр гаргасан. Нэгдүгээрх нь бол Үндсэн хуулиар олгогдоогүй ҮХЦ-д олгогдсон энэ чиг үүргийг бол үнэхээр Үндсэн хуультай зөрчилдөх нийцэхгүй байх тийм үндэслэл байна гээд хуулийг хүчингүй болгохтой холбоотой шийдвэрийг бол дэмжсэн. Ингэж дэмжихдээ бол 2 зүйлийг бол дурдсан. 1 дүгээрт, ҮХЦ иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг энэ шийдвэр бол хязгаарлахгүй гэдэг тийм тайлбар хийсэн. 2-т нь Дээд шүүхэд олгогдсон бүрэн эрх болон Цэцэд олгогдсон бүрэн эрхийн энэ томьёоллууд хоорондоо жоохон зөрөөтэй байгаа шүү. Тийм учраас шүүхийн шинэтгэлийн үйл явцтай холбогдуулаад Дээд шүүхэд олгогдсон томьёоллоо сайжруулах чиглэлээр УИХ анхаарч ажиллаарай гэж бас хэлсэн. Ийм л 2 агуулгатайгаар ҮХЦ шийдвэрээ гаргаад, Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг Үндсэн хуульд нийцэхгүй байна гэдэг агуулгаар шийдвэрээ гаргасан байгаа.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүнд баярлалаа. Хүсэлт гаргасан УИХ-ын гишүүн Тэмүүжингээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Би Тэмүүжин гишүүнээс цаад үр дагаврын талаар асуулт асуух гэсэн юм. Яагаад энэ саналыг гэдэг юм уу, энэ хүсэлтийг гаргах болсон бэ гэдэг нь УИХ-аас томилогддог албан тушаалтан чөлөөлөгдсөн тогтоолоо эргүүлж хүчингүй болгох гэж гэдэг юм уу УИХ-ыг шүүхэд өгсөнтэй холбоотой шүү дээ. Тэгээд тэр асуудлыг бол аль ч шүүх хүлээж авахгүй байсан учраас Цэц рүү очиж, тэндээс харьяаллыг нь тогтооно гэсэн ийм асуудал гарсан учраас эргээд энэ нь бас боломжгүй юм, энэ нь Цэц рүү чиглүүлсэн энэ заалт нь өөрөө буруу юм байна гэдэг ийм шийдвэр гарчхаж байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр тэр УИХ-ыг шүүхэд өгсөн

байгаа энэ асуудал нь одоо энэ хуулийн өөрчлөлтийн дараагаар Дээд шүүх шийдвэрлэж өгнө гэсэн үг үү, эсхүл одоо яана гэсэн үг вэ? Ер нь цаашид энэ УИХ-ын УИХ-аас томилогдож байгаа албан тушаалтнууд эргээд Улсын Их Хурлаа шүүхэд өгч маргаан үүсгэж болно гэсэн үг үү, болохгүй гэсэн үг үү яг нэг цаад агуулгаар нь асуулт асуух гэсэн юм. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Маргаан бол их сонирхолтой маргаан байсан. Монгол Улсын Ерөнхий аудитораар ажиллаж байсан хүн өөрийнхөө хүсэлтээр Ерөнхий аудиторынхаа албан үүргээс чөлөөлөгдье гээд УИХ-аас шийдвэр гаргуулсан. Яагаад өөрийнхөө хүсэлтийг өгсөн бэ гэхээр Ерөнхий аудитор байсан хүн өөрөө Жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлийн сангаас зээл авсан байсан. Хууль бусаар төрийн мөнгө сонирхлын зөрчилтэйгөөр зарагдаж байна уу, үгүй юү гэдгийг хянах үүрэгтэй албан тушаалтан өөрөө албан тушаалынхаа байдлыг ашиглаад зээл авчихсан тохиолдол гараад тэгээд УИХ дээр яригдаад энэ нь өөрөө Авлигатай тэмцэх газар авлигын хэрэг мөн үү гэдэг шалгагдах үйл явц эхлээд, тэгээд албан тушаалтан бол би энэ албан тушаалаасаа чөлөөлөгдье гэж хүсэлт гаргаад УИХ чөлөөлсөн тийм тогтоол гаргасан байсан.

Гэтэл тодорхой хугацааны дараа гэнэт нөгөө албан тушаалтан чинь УИХ-ын энэ тогтоолыг хууль бус гэж үзэж байна гээд шүүхдэнэ гэдэг ийм маргаан гарсан байсан. Энэ маргааныг шүүхэд хэд хэдэн удаа өгсөн боловч шүүх энэ маргааныг бол авч хэлэлцээгүй юм байна лээ. Энэ бол шүүхийн маргаан биш байна гээд. Яагаад гэвэл УИХ-ын шийдвэрийг ердийн шүүх хянах эрхгүй. УИХ-ын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн байвал Үндсэн хуулийн шүүх л хянана. Тийм учраас ердийн шүүх энийг бол хянах боломжгүй гэдэг байдлаар хариу өгсөн байсан.

Иргэн бол ҮХЦ-д гомдол гаргасан. Тэгээд ҮХЦ эхний удаад бол аваагүй юм байна лээ. Дээд шүүхэд бас гомдол гаргасан. Дээд шүүх бас иргэний маргааныг аваагүй юм байна лээ. Тэгээд 2 дахь удаа ҮХЦ-д хандсан. ҮХЦ яг энэ дээр ямар тайлбар өгсөн бэ гэхээр Үндсэн хуулийн, Үндсэн хуульд хэрэг маргаан шийдвэрлэх хууль дээр 14 дүгээр зүйлд нь иргэн гомдол гаргасан чинь шүүх авахгүй байгаа бол харьяалал тогтоох байдлаар ийм шийдвэр гаргаж өгч болно гэдэг ийм заалт байгаа учраас гээд захиргааны анхан шатны шүүх рүү шийдчихсэн, өгчихсөн юм байна лээ. Тэгээд ҮХЦ-ээс ийм шийдвэр ирсэн учраас гээд захиргааны анхан шатны шүүх нь маргаан үүсгэсэн, маргаан үүсгээд УИХ-ыг итгэмжилсэн төлөөлөгчөө томил, энэ шийдвэртэй холбоотой баримтууд нотлох баримтуудаа нааш нь шүүх рүү хүргүүл гэсэн. Тэгэнгүүт УИХ ердийн шүүхэд хянагдах ямар ч боломжгүй учраас шүүх рүү хүргүүлэх боломжгүй болчихсон УИХ.

Нөгөө талаас шүүх энэ асуудлаа шийдмээр байна гээд ингээд 2 эрх мэдэл хоорондоо ингээд үл ойлгогдох байдалтай болчихож байгаа байхгүй юу. Үл ойлгогдох байдалтай болсон байгаа байдал нь нөгөө Цэцийн шийдвэртэй холбоотой байсан. Яг энэ дээр УИХ-аас бол бид Цэцэд хүсэлт гаргах ёстой юм байна гэдэг агуулгаар Цэцэд бид хүсэлт гаргасан. ҮХЦ яг энэ маргааныг шийдэх явцдаа бас шийдвэр дотор дүгнэлт, тогтоох хэсэг болон шийдвэрийн дүгнэлт хэсэг дээр байхгүй байх. Гэхдээ хуралдаан дотор яригдсан нэг зүйл бол шүүх бол иргэний гомдлыг бол хүлээж авах ёстой байсан. Гомдлыг нь хүлээж авчхаад энэ шүүхийн маргаан биш байна гэдгээ үндэслэлтэйгээр бол тайлбарлах ёстой байсан. Гэтэл гомдлыг нь зүгээр хүлээж авахгүй байгаа. Тэгэхээр шударгаар шүүлгэх эрх бол хангагдахгүй

байна. Шүүх бол гомдлыг нь хүлээж аваад маргаан үүсгэх юм уу яадаг юм нэг тийм процесс яваад гэхдээ энэ шүүхэд харьяалагдах маргаан биш байна гэдгээ үндэслэлтэйгээр тайлбарлаад шийдвэрээ гаргах ёстой энэ процесс ерөөсөө явагдахгүй байгаа нь шударга шүүхээр шүүлгэх эрх бол хангагдахгүй байна гэдэг үндэслэл байж болох юм байна шүү гэдгийг бол маш тодорхой ярьсан.

Тэгээд Цэц бол юу гэсэн гэхээр одоо байгаа тухайн үед хүчин төгөлдөр байсан Цэц түдгэлзүүлээгүй байсан Цэцийн хэрэг маргаан шийдвэрлэх хуулийн 14 дүгээр зүйл бол зохимжгүй байна. Гэхдээ иргэний.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Үзэж сонирхож байгаа. Нэмж, Тэмүүжин гишүүн нэмж нэг минут.

Х.Тэмүүжин: Цэц бол шүүхийн харьяалал тогтоож шүүх ингэж шийд гэдэг ийм маргаанд ингэж авч үз гэдэг байдлаар шийдвэрлэх бол Үндсэн хуулийн хувьд бол зохимжгүй, нийцээгүй юм байна угаасаа. Тэрийг бол хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ иргэн шударга шүүхээр шүүлгэх эрх маань хангагдахгүй байна гээд үндсэн эрхийн маргааны байдлаар дахиад ийм гомдлууд бичвэл энэ бол Үндсэн хуулийг, ҮХЦ-ийн эрх мэдлийг хязгаарлаагүй шүү. Яагаад гэвэл Үндсэн хуулийн 64 дүгээр зүйл болон 66 дугаар зүйл дээр энэ төрлийн маргааныг шийдвэрлэх боломж нээлттэй мэт байдлаар томьёологдсон байгаа юм байна шүү гэдгийг бас давтаж хэлсэн. Тэгэхээр бид бол энэ 2-ыг ялгах ёстой. Шүүх яаж ажиллах тухайг Цэц шийдэж болохгүй. Гэхдээ иргэний үндсэн эрхийн маргааныг бол шийдвэрлэх эрх байж болзошгүй шүү гэдэг тийм тайлбартайгаар шийдвэрлэсэн.

Ц.Сандаг-Очир: Болсон уу, Ариунзаяа гишүүн болсон уу? 1 минут тодруулъя Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Дахиад хэлье. Ер нь үндсэндээ миний ойлгосноор УИХ-ыг шүүхэд хандаж өөртэйгөө холбоотой тэр тогтоолыг маргаан үүсгэх эрх нь бол нээлттэй хэвээрээ үлдсэн юм байна гэж таны хариултаас ойлголоо зөв үү?

Ц.Сандаг-Очир: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Тухайн иргэний маргаан шүүхээр шийдвэрлэгдэх бол боломжгүй. Тэгэхдээ шүүх гомдлыг хүлээж авах ёстой гэдэг. Яагаад гэвэл энэ чинь парламентын шийдвэр бол бодлогын шийдвэр. Тэгээд олон улсад бол political questions гэдэг ойлголт байдаг. Шүүх бол бодлогын шийдвэрийг авч хэлэлцэхгүй гэдэг зарчимтай ердийн шүүх. Бодлогын шийдвэр нь Үндсэн хуультай зөрчилдсөн байвал Үндсэн хуулийн шүүх үүнийг нь авч хэлэлцэх эрхтэй гэдэг бас зарчимтай. Тэгэхээр УИХ-аас гаргасан тэр дундаа албан тушаалтныг томилсон, чөлөөлсөн шийдвэрүүд бол бүгдээрээ бодлогын шийдвэр улс төрийн шийдвэр. Хэрвээ энэ янзаараа хэрвээ цааш ингээд үргэлжилбэл Засгийн газар Ерөнхий сайдыг чөлөөлсөн, Засгийн газрыг огцруулсан гэх мэт шийдвэрүүдийг захиргааны шүүхэд гомдол гаргах юм уу. Дэлхий нийтээрээ бол ийм зарчим байхгүй. Энэ нь Үндсэн хуулийн бус байна гэвэл Үндсэн хуулийн шүүх л авч хэлэлцэх эрхтэй. Тэгэхлээр.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явагдана. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14

дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож, холбогдох шүүхэд шилжүүлнэ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 70 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Монгол Улс, хэлнэ одоо дэг байхгүй дээ. 1 минут Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Цэцийн дүгнэлтийг хүлээж авсантай холбогдуулаад УИХ одоо 3 ажил хийх хэрэгтэй болчхож байгаа. 1 дүгээрт, мэдээж.../үг тасрав/

Ц.Сандаг-Очир: Гэхдээ эцэслэн Их Хурлаар ороогүй байгаа шүү дээ.

Х.Тэмүүжин: Цэцэд хэрэг хянан шийдвэрлэхдээ, Цэцэд хэрэг маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой 14 дүгээр зүйлийг бол хүчингүй болгох ёстой болно. 2-т нь Цэцийн хуралдаанд яригдсан нэг зүйл бол Дээд шүүхэд олгогдсон энэ эрх сая Цэцийн хууль дээр байсан зүйл 2 чинь бас утга агуулгын хувьд хэр уялдаатай байгаа юм бэ гэдгийг сайн хараарай. Дээд шүүхийн тэр хэсэг чинь Цэцийн хуулиас жоохон дутмаг бичигдсэн байна лээ шүү гээд. Тэгэхээр тэр хуулиа боловсронгуй болгох чиглэлээр ажиллаарай гэдэг чиглэл бас яригдсан. 3-д нь энэ үндсэн эрхтэй холбоотой асуудлаа шийдэхгүй бол энэ мэт гомдол саналууд бас хий хоосон хамгаалалтгүй үлдэх боломж байгаа шүү. Тийм учраас Цэцэд үндсэн эрхийн маргаан шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомжийг баталж, боловсронгуй болгох чиглэлээр УИХ санаачилга гаргаж ажиллаасай гэж хэлсэн байгаа шүү.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа гишүүн. Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Ариунзаяа гишүүн танилцуулна.

12.38 цаг

Гурав.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

3 дахь асуудалдаа оръё. Монгол УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцье. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан ТББХ хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. УИХ-д өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдье гишүүд. Болсон уу? Бямбаа дарга орчихсон юм уу, санал хураалтдаа? 3 санал хураалт байна.

УИХ-ын гишүүн Т.Мөнхсайхан нарын 3 гишүүн 2025 оны 12 сарын 31-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

2.УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 2 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Санхүүгийн хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасныг дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2026 оны 3 сарын 9-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 18 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

12.41 цаг

Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ талархлаа. Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Өнөөдөр орчин цагийн зэвсэгт хүчин үүсэж байгуулагдсаны 105 жилийн ой, Монгол цэргийн баярын өдөр учраас Байнгын хорооныхоо эрчүүддээ эр цэргийн баярын өдрийн мэндийг дэвшүүлье. Хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА